



31 181

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/144

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангаас сургалтын төлбөр
болон амьжиргааны зардлын зээл олгох тухай

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Засгийн газрын 2011 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгодог урлаг-II” үндэсний хөтөлбөрийн 4.3.6 дахь заалт, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 1а/672 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Соёл, спорт, аялал жуулчлалын яамны захиалгаар 2012-2013 оны хичээлийн жилд АНУ-ын Нью Йорк хотын их сургуульд зураачийн мэргэжлээр суралцах (Эрдэнэбаяр овогтой Жанцанхоролын) сургалтын төлбөр, Польш Улсын Карол Шимановскийн хөгжмийн академид төгөлдөр хуурч мэргэжлээр суралцах (Нямаа овогтой Ичингийн) сургалтын төлбөр болон амьжиргааны зардал, Франц Улсын Хөгжмийн үндэсний их сургуульд удирдаач, хийлч мэргэжлээр суралцах (Баярбаатар овогтой Нандингуагийн) сургалтын болон амьжиргааны тэтгэлэг, ХБНГУ-ын Мюнстер хотын Хөгжмийн дээд сургуульд хөгжим судлаач мэргэжлээр суралцах (Алтай овогтой Мөнхцацалын) сургалтын төлбөр болон амьжиргааны тэтгэлэг, ОХУ-ын Театр, урлагийн дээд сургуульд театрын найруулагч мэргэжлээр суралцах (Мягмарнаран овогтой Батболдын) сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг суралцах сургалтын болон амьжиргааны зардалд зориулж нийт 83,267,406.96 /наян гурван сая хоёр зуун жаран долоон мянга дөрвөн зуун зургаан төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөгийг Сургалтын төрийн сангийн зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсүгэй.

2. Суралцагчтай Сургалтын төрийн сангийн зээлээр суралцах гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР